ГАРЧИГ

Товч танилцуулга

Үндсэн үзүүлэлт

**I.Нийгмийн үзүүлэлт**

I.1 Хүн ам

I.2 Хөдөлмөр

I.3 Нийгмийн даатгал, нийгмийн халамж

I.4 Эрүүл мэнд

I.5 Гэмт хэрэг

**II.Эдийн засгийн үзүүлэлт**

II.1 Банк

II.2 Төсөв

II.3 Үнэ

II.4 Хөдөө аж ахуй

II.5 Аж үйлдвэр

II.6 Холбоо

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2018 ОНЫ**

**11-Р САРЫН ТАНИЛЦУУЛГА**

## I. Нийгмийн үзүүлэлт

### I.1. Хүн ам

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 11-р сард 2214 хүүхэд шинээр мэндэлж, 602 хүн нас барсан байна. Хүн амын цэвэр өсөлт 1612 болж өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 19.1, нас баралт 5.2 байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад  нас баралт 0.4 пунктээр өсч, төрөлт 0.2 пунктээр буурсан байна.

**Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо**




### I.2 Хөдөлмөр

**Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо**

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 869 болж өмнөх оны мөн үеийнхээс 548 хүнээр буюу 38.7 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 550 буюу 63.3 хувь нь 15-34 насны залуучууд байна.

11 сарын байдлаар ажилгүй 178 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй иргэдээс 71 иргэн ажилд зуучлагдан оржээ.

Эхний 11 сарын байдлаар 1024 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 211-ээр буюу 17.1 хувиар буурсан байна. Шинэ ажлын байрны 6.9 хувь нь боловсролын салбарт, 13.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 4.6 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 11.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбарт, 64.3 хувь нь бусад салбарт бий болсон байна.

## I.3 Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого эхний 11 сард 56.1 тэрбум.төг, зарлага 55.6 тэрбум.төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 7.1 тэрбум.төг буюу 14.5 хувиар, зарлага 7.5 тэрбум.төг буюу 15.6 хувиар тус тус өсчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогын 93.0 хувийг тэтгэврийн даатгалын сангийн орлого, 0.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, 2.3 хувийг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого, 3.8 хувийг тэтгэмжийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 7.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 7.0 тэрбум.төг буюу 15.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн даатгалд даатгуулагчдын 58.9 хувь нь заавал даатгуулагчид, 41.1 хувь нь сайн дураар даатгуулагчид байна.Сайн дураар даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 287 хүнээр буюу 3.1 хувиар өсчээ. Заавал даатгуулагчдын 42.3 хувь нь аж ахуйн нэгж байгууллагад, 57.7 хувь нь төсөвт байгууллагад ажиллаж байна.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 11 сарын байдлаар/ давхардсан тоогоор/ 39329 хүнд 13.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын тоо 1337 хүн буюу 3.5 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 3.6 тэрбум.төг буюу 36.7 хувиар тус тус өсчээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсадын 4.2 хувийг халамжийн тэтгэвэр авагчид, 5.8 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдагсад, 8.4 хувийг ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид хамрагдагсад, 2.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлтөд хамрагдагсад эзэлж байна.

## I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эхний 11 сард 2215 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 19 эхээр буюу 0.9 хувиар, төрсөн хүүхдийн тоо ( амьд төрөлтөөр) 2214 болж 9 хүүхэд буюу 0.4 хувиар тус тус өссөн байна.




Нэг хүртэлх насандаа 35 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хүүхдээр, 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 1 хүүхдээр тус тус буурсан байна.

Халдварт өвчнөөр эхний 11 сард 915 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 130 хүнээр буюу 12.5 хувиар буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 22.2 хувь нь цусан суулга өвчнөөр өвчлөгчид байна. Өмнөх оны мөн үеийнхээс цусан суулга өвчнөөр өвчлөгчдийн тоо 84 хүнээр буюу 70.5 хувиар, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 26 хүнээр буюу 34.2 хувиар өсч, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 249 хүнээр, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 63 хүнээр, трихоминиазаар өвчлөгчдийн тоо 12 хүнээр тус тус буурсан байна.

## I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 11 сард 637 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 210 гэмт хэргээр буюу 49.2 хувиар өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 57.3 хувь нь сумдад, 42.7 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 15 болж өмнөх оны мөн үеийнхтэй адилхан байна. Хулгайлах гэмт хэргийн 64.7 хувийг иргэдийн орон байрны хулгай, 14.9 хувийг малын хулгай, 20.4 хувийг авто тээврийн хэрэгслийн хулгай эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдсон 455 сэжигтэн, яллагдагчийн 258 хүн буюу 56.7 хувь нь 18-35 хүртэл насных, 142 хүн буюу 31.2 хувь нь 35-аас дээш насных, 22 хүн буюу 4.8 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 16.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 34.9 хувь нь ажилчин, малчин, 4.6 хувь нь оюутан, сурагч, 44.0 хувь нь ажилгүй иргэд байна.

Авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 790 болж өмнөх оны мөн үеийнхээс 181 хүнээр буюу 29.7 хувиар, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүний тоо 17.5 хувиар өссөн байна. Хэрэг үйлдэгчдийн 37.6 хувь нь согтуугаар, 23.1 хувь нь бүлэглэн үйлдсэн хэрэг эзэлж байна.Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 76.3 хувиар өсчээ.

Гэмт хэргийн улмаас 1003.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.0 сая төгрөг буюу 0.4 хувиар буурчээ. Нийт хохирлын 38.4 хувь буюу 385.5 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 39 хүн нас баржээ. Аймгийн хэмжээнд эхний 11 сард 1393 хүн албадан эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 269 хүн буюу 23.9 хувиар өссөн байна.

## II. Эдийн засгийн үзүүлэлт

### II.1 Банк

Арилжааны банкуудын мэдээгээр аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 11 сарын байдлаар 211.6 тэрбум төгрөг болжээ. Нийт зээлийн 1.1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Байгууллага иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 124.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 17.6 тэрбум төгрөг буюу 16.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны мөн үеийнхээс зээлжигчийн тоо 210 хүн буюу 0.6 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 4.3 хувиар өссөн байна.

### II.2 Төсөв

**Орлого:** 2018 оны эхний 11 сард орон нутгийн төсвийн орлогод 14.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 106.1 хувьтай байна. Орлогын 66.1 хувь нь татварын орлого, 33.9 хувь нь татварын бус орлого байна.

**Орон нутгийн орлогын бүтэц, хувиар**




**Зарлага:** Орон нутгийн төсвийн зарлага 67.3 тэрбум.төг болж өмнөх оны мөн үеийнхээс 3.7 тэрбум.төг буюу 5.8 хувиар өссөн байна. Нийт зарлагын 45.3 хувийг цалин хөлс, 5.5 хувийг НДШ, 8.2 хувийг байр ашиглалттай холбоотой зардал, 16.2 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 1.7 хувийг хангамж, бараа материалын зардал, 23.1 хувийг бусад зардал эзэлж байна.

**Төсвийн зарлагын бүтэц, хувиар**




## II.2 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

2018 оны 11-р сарын бараа үйлчилгээний үнэ тариф өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.8 хувиар, өмнөх сарынхаас 1.8 хувиар өсчээ. Өмнөх сарынхаас шимийн сүүний дундаж үнэ 14.9 хувиар, хорхой ааруулын дундаж үнэ 2.4 хувиар, аарцны дундаж үнэ 23.5 хувиар, шар тосны дундаж үнэ 3.6 хувиар, өндөгний дундаж үнэ 0.2 хувиар, үхрийн ястай махны дундаж үнэ 5.7 хувиар, үхрийн цул махны дундаж үнэ 7.1 хувиар, хонины ястай махны дундаж үнэ 0.2 хувиар, ямааны ястай махны дундаж үнэ 0.9 хувиар, адууны ястай махны дундаж үнэ 10.5 хувиар, мандарины дундаж үнэ 11.1 хувиар, алимны дундаж үнэ 4.2 хувиар, А-80 бензиний дундаж үнэ 5.2 хувиар, АИ-92 бензиний дундаж үнэ 4.6 хувиар, дизель түлшний дундаж үнэ 6.5 хувиар өсч, луувангийн дундаж үнэ 13.3 хувиар, манжингийн дундаж үнэ 33.3 буурсан байна.

## II.4 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцэст төллөх насны нийт 2285.5 мянган эх мал тоологдсон ба 2018 оны эхний 11 сарын байдлаар 1532.1 мянган толгой эх мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 67.0 хувь нь төллөсөн байна. Ингэний 43.0 хувь, гүүний 43.3 хувь, үнээний 64.8 хувь, эм хонины 74.4 хувь, эм ямааны 61.8 хувь нь төллөжээ. Өмнөх оны мөн үед нийт эх малын 90.6 хувь буюу 1896.2 мянган мал төллөсөн байжээ.

## Мал төлөлтийн хувь




Гарсан төл 84.8 хувьтай бойжиж байна. Ботго 98.9 хувь, унага 87.8 хувь, тугал 90.0 хувь, хурга 88.8 хувь, ишиг 78.3 хувьтай бойжиж байна. Өмнөх оны мөн үед төл бойжилтын хувь 97.1 хувьтай бойжиж байсан байна.

## Төл бойжилтын хувь




Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар оны эхэнд тоологдсон нийт малын 5.1 хувьтай тэнцэх 295.2 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байна. Нийт хорогдсон малын 0.04 хувийг тэмээ, 9.9 хувийг адуу, 8.6 хувийг үхэр, 35.6 хувийг хонь, 45.8 хувийг ямаа эзэлж байна.

Хорогдлыг сумдаар авч үзвэл Бүрд суманд 44.2 мянган толгой мал буюу хамгийн олон мал хорогдсон байна. Өлзийт суманд 23.1 мянган толгой, Есөнзүйл суманд 22.3 мянган толгой, Хужирт суманд 21.5 мянган толгой, Хархорин суманд 21.3 мянган толгой, Баян-Өндөр суманд 20.9 мянган толгой, Хайрхандулаан суманд 19.8 мянган толгой, Баруунбаян-Улаан суманд 18.5 мянган толгой,Тарагт суманд 17.7 мянган толгой, Сант суманд 17.1 мянган толгой, Уянга суманд 13.9 мянган толгой, Арвайхээр суманд 11.8 мянган толгой, Нарийнтээл суманд суманд 11.7 мянган толгой, Бат-Өлзий суманд 9.9 мянган толгой, Баянгол суманд 8.9 мянган толгой, Гучин-Ус суманд 7.8 мянган толгой мал тус тус хорогдсон, хамгийн бага буюу Богд, Зүүнбаян-Улаан суманд 1.3 мянган толгой, Төгрөг суманд 2.1 мянган толгой мал хорогджээ.

## Хорогдсон том мал, сумдаар, мянган толгой




Эхний 11 сарын байдлаар өвчнөөр 11.3 мянган толгой мал хорогдсон нь Баян-Өндөр, Бүрд, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Богд, Төгрөг, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдад хорогдсон байна.

Нийт хорогдсон том малын 80.4 мянга нь буюу 27.2 хувь нь  хээлтэгч мал байгаа ба хээлтэгчийн хорогдлын 44.8 хувийг эм ямаа эзэлж байна.

Аймгийн түүхий эдийн захад тэмээний шир 10.0 мянган төгрөг, адууны шир 10.0 мянган төгрөг, адууны дэл кг нь 7.0 мянган төгрөг, адууны сүүл кг нь мөн 10.0 мянган төгрөг, үхрийн жижиг шир 5.0, том шир 12.5 мянган төгрөг, ямааны арьс 28.0 мянган төгрөгийн үнэ ханштай байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад адууны сүүл 66.7 хувиар, ямааны арьс 3.7 хувиар тус тус өссөн байна. Адууны шир 52.4 хувиар, адууны дэл 17.6 хувиар, тэмээний шир 33.3 хувиар, үхрийн жижиг шир 80.0 хувиар, үхрийн том шир 58.3 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх сартай харьцуулбал адууны сүүл 11.1 хувиар, адууны шир 11.1 хувиар, үхрийн жижиг шир 25.0 хувиар, үхрийн том шир 38.9 хувиар, ямааны арьс 41.1 хувиар тус тус өссөн, адууны дэл 22.2 хувиар буурсан байна. Тэмээний ширний үнэ өмнөх сарын түвшинд байна.

## Малын гаралтай зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ



Аймгийн хэмжээнд 5893.5 га-д үр тариа тариалсан ба үүний 5818.0 га-д буудай, 45.5 га-д арвай, 30 га-д овъёос тариалсан үр тариа тариалалт өмнөх оноос 2324.0 га-р бага хийгдсэн байна. 373.0 га-д төмс, 210.9 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 22.1 га-гаар, хүнсний ногоо 2.7 га-гаар бага тариалсан.

Ургац хураалт 10 сарын 30-ны байдлаар 5200 тн буудай, 5 тн арвай, 9 тн овъёос, 4152.6 тн төмс, 2134.5 тн хүнсний ногоо, 3.5 мянган тн малын тэжээл, 470 тн рапс хураан аваад байна.

Малчдын өөрсдийн бэлтгэсэн хадлан 22.3 мянган тн, гаднаас худалдаж авсан нь 11.7 мянган тн байна. Нийт бэлтгэсэн хадлан нь өмнөх оны мөн үеэс 5.6 мянган тн-оор илүү байна. Гар тэжээл 14.4 мянган тн-ийг бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.4 мянган тн-оор илүү байна.

## II.5 Аж үйлдвэр

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 11 сард 36.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.5 тэрбум төгрөгөөр буюу 66.1 хувиар өссөн байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд: Бялуу, нарийн боов, хэрчсэн гурил, хиам, архи, цэвэр ус, рашаан, гэрийн мод, барилгын материал, нүдний шил зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.1 хувиас, 6.8 дахин өссөн байна. Харин сүү, сүүн бүтээгдэхүүн, хөлдөөсөн бууз, аарц, ааруулны үйлдвэрлэлт 61.2- 80.3 хувиар буурсан байна.

## II.Холбоо

Эхний 11 сарын байдлаар холбооны орлого 395.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 28.9 сая төгрөг буюу 7.9 хувиар, хүн амаас орсон орлого 11.5 сая төгрөг буюу 38.0 хувиар тус тус өссөн байна.

Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 5841 болж өмнөх оны мөн үеийнхээс 316 хүнээр буюу 5.1 хувиар буурсан байна.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2017-XI | 2018-XI | 2018/2017% |
|---|---|---|---|---|
| **Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд** | | | | |
| Төрсөн хүүхэд | хүн | 2205 | 2214 | 100.4 |
| Нас баралт | хүн | 549 | 602 | 109.7 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд | хүн | 1417 | 898 | 63.4 |
| Шинэ ажлын байранд ажилд орсон иргэд | хүн | 1235 | 1024 | 82.9 |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | сая төгрөг | 49023.0 | 56128.9 | 114.5 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | сая төгрөг | 48111.1 | 55604.6 | 115.6 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо | хүн | 1045 | 915 | 87.6 |
| Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | тоо | 477 | 637 | 133.5 |
| Хэрэгт холбогдогсод | хүн | 380 | 455 | 119.7 |
| **Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд** | | | | |
| Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулсан | хувь | 102.8 | 109.8 | - |
| Зээлийн өрийн үлдэгдэл | сая.төг | 171.4 | 211.6 | 123.5 |
| Иргэдийн хадгаламж | сая.төг | 106.6 | 124.2 | 116.5 |
| Зээлжигчийн тоо | хүн | 35999 | 36209 | 100.6 |
| Хадгаламж эзэмшигчийн тоо | хүн | 76708 | 79997 | 104.3 |
| орон нутгийн төсвийн орлого | сая төгрөг | 11800.0 | 14196.4 | 120.3 |
| Төсвийн зарлага | сая төгрөг | 93597.3 | 67349.5 | 72.0 |
| Том малын зүй бусын хорогдол | толгой | 23.5 | 295.2 | 12.5 дах |
| Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | сая.төг | 21897.4 | 36376.2 | 166.1 |

## I.1 ХҮН АМ

### I.1.1 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ХҮН АМЫН ЕРДИЙН ӨСӨЛТ, сумаар

| Сум | 2017-XI | | | 2018-XI | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төрөлт | Нас баралт | Ердийн цэвэр өсөлт | Төрөлт | Нас баралт | Ердийн цэвэр өсөлт |
| БҮГД | 2205 | 549 | 1656 | 2214 | 602 | 1612 |
| Баян-Өндөр | 6 | 18 | -12 | 2 | 24 | -22 |
| Бүрд | 12 | 16 | -4 | 15 | 14 | 1 |
| Бат-Өлзий | 58 | 37 | 21 | 60 | 37 | 23 |
| ББ-Улаан | 6 | 16 | -10 | 5 | 17 | -12 |
| Баянгол | 5 | 15 | -10 | 9 | 22 | -13 |
| Гучин-Ус | 12 | 6 | 6 | 8 | 7 | 1 |
| Есөнзүйл | 19 | 14 | 5 | 6 | 18 | -12 |
| Өлзийт | 4 | 5 | -1 | 7 | 7 | 0 |
| ЗБ-Улаан | 9 | 22 | -13 | 2 | 17 | -15 |
| Богд | 31 | 23 | 8 | 42 | 36 | 6 |
| Нарийнтээл | 7 | 15 | -8 | 6 | 12 | -6 |
| Сант | 5 | 12 | -7 | 7 | 19 | -12 |
| Тарагт | 1 | 20 | -19 | 1 | 23 | -22 |
| Төгрөг | 7 | 13 | -6 | 4 | 8 | -4 |
| Уянга | 90 | 42 | 48 | 77 | 54 | 23 |
| Хайрхандулаан | 20 | 13 | 7 | 20 | 13 | 7 |
| Хужирт | 34 | 39 | -5 | 79 | 48 | 31 |
| Хархорин | 265 | 30 | 235 | 234 | 33 | 201 |
| Арвайхээр | 1614 | 193 | 1421 | 1630 | 193 | 1437 |

*Эх үүсвэр: Аймгийн эрүүл мэндийн газар*

## I.2 ХӨДӨЛМӨР

I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО

| Үзүүлэлт | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|
| **1. Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд** | **1618** | **898** |
| **2. Тайлант сард нэмэгдсэн ажилгүйчүүд** | **473** | **178** |
| **3. Ажилгүйчүүдээс тайлант сард ажилд орсон** | **308** | **71** |
| **4. Тайлант сард ажилгүйчүүдийн бүртгэлээс хасагдсан** | **366** | **136** |
| **5. Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд** | **1417** | **869** |
| **6. Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд насны бүлгээр** | | |
| 15-24 | 360 | 255 |
| 25-34 | 499 | 295 |
| 35-44 | 306 | 195 |
| 45-60 | 252 | 124 |

*Эх сурвалж: ХХҮГ-ын мэдээг үндэслэв*



## I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсролоор

| Сумын нэр | Бүгд | Боловсролын түвшингээр | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дээд | Тусгай дунд | Мэргэжлийн анхан шатны | Бүрэн дунд | Бүрэн бус дунд | Бага | Боловсролгүй |
| Дүн | 869 | 197 | 10 | 182 | 376 | 60 | 34 | 10 |
| Баян-Өндөр | 6 | 2 | | | 3 | 1 | | |
| Бүрд | 9 | 1 | | | 5 | 1 | 2 | |
| Бат-Өлзий | 9 | | | 4 | 5 | | | |
| Баруунбаян-Улаан | 7 | 5 | | | 2 | | | |
| Баянгол | 11 | 1 | | | 9 | 1 | | |
| Гучин-Ус | 7 | 1 | | 2 | 4 | | | |
| Есөнзүйл | 9 | 2 | | | 3 | 1 | 3 | |
| Өлзийт | 8 | 2 | | 1 | 4 | 1 | | |
| Зүүнбаян-Улаан | 23 | 4 | | 13 | 2 | 1 | 2 | 1 |
| Богд | 27 | 5 | | 15 | 7 | | | |
| Нарийнтээл | 21 | 3 | | 7 | 8 | 2 | 1 | |
| Сант | 22 | 4 | | 2 | 9 | 7 | | |
| Тарагт | 23 | 5 | | 6 | 11 | 1 | | |
| Төгрөг | 8 | 2 | 1 | 2 | 3 | | | |
| Уянга | 37 | 7 | | 12 | 15 | 1 | 2 | |
| Хайрхандулаан | 16 | 1 | | 6 | 8 | | | 1 |
| Хужирт | 19 | 2 | 2 | 7 | 6 | | 1 | 1 |
| Хархорин | 93 | 24 | | 20 | 43 | 4 | 2 | |
| Арвайхээр | 514 | 126 | 7 | 85 | 229 | 39 | 21 | 7 |

*Эх сурвалж: ХХҮГ-ын мэдээг үндэслэв*

I.2.3 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, салбараар

| | Хүний тоо | | Салбараар | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017-XI | 2018-XI | ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур | Боловсруулах үйлдвэр | Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж | Барилга | Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар,үйлчилгээ | Мэдээлэл холбоо | Боловсрол | Бусад |
| **Бүгд** | **1235** | **1024** | **47** | **133** | **2** | **328** | **115** | **1** | **71** | **327** |
| Баян-Өндөр | 12 | 28 | 2 | 4 | | 15 | 5 | | 1 | 1 |
| Бүрд | 2 | | | | | | | | | |
| Бат-Өлзий | 18 | 28 | | | | | 3 | | | 25 |
| Баруунбаян-Улаан | 7 | 3 | | | 1 | | | | 2 | |
| Баянгол | 38 | 49 | 11 | 3 | | 8 | 26 | | | 1 |
| Гучин-Ус | 4 | 18 | | | | 10 | | | | 8 |
| Есөнзүйл | 23 | 15 | 1 | | | | 14 | | | |
| Өлзийт | 28 | 32 | 20 | 4 | | 1 | 1 | | 2 | 4 |
| Зүүнбаян-Улаан | 42 | 11 | 5 | | | | 2 | | | 4 |
| Богд | 23 | 29 | | | | 13 | 1 | | 7 | 8 |
| Нарийнтээл | 55 | 9 | | | | 5 | | | 3 | 1 |
| Сант | 2 | 26 | | | | 14 | 2 | | | 10 |
| Тарагт | 25 | 45 | 2 | | | 28 | 1 | | | 14 |
| Төгрөг | 28 | 9 | | | | | | | 1 | 8 |
| Уянга | 79 | 83 | | 8 | | | | | | 75 |
| Хайрхандулаан | 35 | 42 | 2 | | | 2 | 3 | 1 | 2 | 32 |
| Хужирт | 74 | 30 | | 20 | | | 1 | | 9 | |
| Хархорин | 122 | 62 | | 11 | | 15 | | | 1 | 35 |
| Арвайхээр | 618 | 505 | 4 | 83 | 1 | 217 | 56 | | 43 | 101 |

## I.3 НИЙГМИЙН ДААТГАЛ,ХАЛАМЖ

I.3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО,ЗАРЛАГА, төрлөөр

| Үзүүлэлт | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|
| **Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг** | **49023** | **56128.9** |
| Үүнээс: | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 45518.5 | 52224.9 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 1775.1 | 2082.2 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангийн | 1263.8 | 1311.4 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 465.6 | 510.4 |
| **Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг** | **48111.1** | **55604.6** |
| Үүнээс: | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 44744.5 | 51723.7 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 1748.1 | 2085.4 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангийн | 1199.1 | 1327.5 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 419.4 | 468.0 |
| **НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД** | | |
| 1.Заавал даатгуулагчид | 13379 | 13638 |
| Үүнээс: | | |
| Аж ахуйн нэгж байгууллага | 5642 | 5767 |
| Төсөвт байгууллага | 7737 | 7871 |
| 2. Сайн дураар даатгуулагчид | 9200 | 9487 |

ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, сая.төг

| Үзүүлэлт | 2017-X | | 2018-X | |
|---|---|---|---|---|
| | хүний тоо | Олгосон хэмжээ | хүний тоо | Олгосон хэмжээ |
| **Нийт олгосон тэтгэвэр, сая.төг** | **15126** | **44728.9** | **16118** | **51534.3** |
| Өндөр настны | 11185 | 34203.9 | 12113 | 39512 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | 2810 | 6876.9 | 2867 | 7982.1 |
| Тэжээгчээ алдсаны | 870 | 2243.8 | 861 | 2403.6 |
| Цэргийн | 261 | 1404.3 | 277 | 1636.6 |

*Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс*

*Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин*

I.3.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ /сая.төг/

| Үзүүлэлт | 2017-XI | | 2018-XI | |
|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Олгосон хэмжээ | Хүний тоо | Олгосон хэмжээ |
| **1.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж** | **4622** | **3676.3** | **3968** | **3824.7** |
| **Халамжийн тэтгэвэр** | **2359** | **2387.3** | **1675** | **2435.9** |
| **Нөхцөлт мөнгөн тэтгэмж** | **2263** | **1289** | **2293** | **1388.8** |
| Ахмад настныг асарч буй иргэний | 1300 | 731.7 | 1314 | 773.1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний | 535 | 288.3 | 504 | 308.4 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч буй иргэний | 308 | 183.2 | 366 | 224.7 |
| Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний тэтгэмж | 92 | 68.8 | 87 | 67.1 |
| Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж | 15 | 8.8 | 10 | 7.5 |
| Ахмад настныг гэртээ асарч буй иргэн | 13 | 8.2 | 12 | 8.0 |
| **2.Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж** | **4800** | **1082.5** | **3057** | **423.8** |
| **3. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн өрх** | **2233** | **1097.0** | **2147** | **932.3** |
| **4.Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж** | **10078** | **894.3** | **3323** | **1018.1** |
| **5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт тусламж** | **1066** | **277.1** | **1079** | **238.5** |
| **6.Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж** | **27** | **53.4** | **37** | **65.0** |
| **Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлсэн хөнгөлөлт тусламж** | **9992** | **1348.3** | **10185** | **1351.8** |
| **Хүнс тэжээлийн хөтөлбөр** | | **879.4** | | **1384.1** |
| **Насны хишиг** | **5174** | **859.6** | **5261** | **856.2** |
| **Цалинтай ээж** | | | **7618** | **3228.0** |
| **ОНОТХҮйлчилгээ** | | | **1941** | **404.3** |
| **Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж** | | | **713** | **171.2** |
| **ДҮН** | **37992** | **10167.9** | **39329** | **13898.0** |

*Эх үүсвэр: ХХҮГ-ын мэдээг үндэслэв.*

## I.4 ЭРҮҮЛ МЭНД

I.4.1 ТӨРӨЛТ, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТОО

| Хугацаа | Амаржсан эх | Амьд төрсөн хүүхэд | Төрөхийн улмаас эндсэн эх | 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд |
|---|---|---|---|---|---|
| 2016-XI | 2464 | 2470 | 2 | 52 | 20 |
| 2017-XI | 2196 | 2205 | - | 39 | 10 |
| 2018-XI | 2215 | 2214 | - | 35 | 9 |

I.4.2 ТӨРӨЛТ, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

| Сумд | Амаржсан эх | Амьд төрсөн хүүхэд | Төрөхийн улмаас эндсэн эх | 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд |
|---|---|---|---|---|---|
| Баруунбаян-Улаан | 5 | 5 | | | |
| Бат-Өлзий | 60 | 60 | | 3 | |
| Баянгол | 9 | 9 | | | 1 |
| Баян-Өндөр | 3 | 2 | | | |
| Богд | 42 | 42 | | 2 | 1 |
| Бүрд | 15 | 15 | | | |
| Гучин-Ус | 8 | 8 | | | |
| Есөнзүйл | 6 | 6 | | | 1 |
| Зүүнбаян-Улаан | 2 | 2 | | | |
| Нарийнтээл | 6 | 6 | | | |
| Өлзийт | 7 | 7 | | | |
| Сант | 7 | 7 | | | |
| Тарагт | 1 | 1 | | 1 | |
| Төгрөг | 4 | 4 | | | 1 |
| Уянга | 78 | 77 | | 5 | |
| Хайрхандулаан | 20 | 20 | | | 1 |
| Хархорин | 234 | 234 | | 2 | 2 |
| Хужирт | 79 | 79 | | | |
| Арвайхээр | 1629 | 1630 | | 22 | 2 |
| **ДҮН** | **2215** | **2214** | **0** | **35** | **9** |

I.4.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО

| Хугацаа | Халдварт өвчнөөр өвчлөгчид-бүгд | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Вирусt гепатит | Цусан суулга | Сурьеэ | Салхинцэцэг | Тэмбүү | Заг хүйтэн | Трихомониаз | Улаан бурхан | Бруцеллёз | Бусад |
| 2016-XI | 2085 | 16 | 38 | 59 | 263 | 152 | 54 | 37 | 1405 | 4 | 57 |
| 2017-XI | 1045 | 5 | 119 | 66 | 382 | 231 | 76 | 97 | | 5 | 64 |
| 2018-XI | 915 | 6 | 203 | 39 | 133 | 168 | 102 | 85 | | 4 | 175 |

I.4.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

| Сумд | Халдварт өвчнөөр өвчлөгчид-бүгд | | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2018 | Вирусt гепатит | Цусан суулга | Сурьеэ | Салхинцэцэг | Тэмбүү | Заг хүйтэн | Трихомониаз | Улаан бурхан | Бруцеллёз | Бусад |
| Баруунбаян-Улаан | 15 | 20 | 7 | 1 | | 2 | | 2 | | | | | 2 |
| Бат-Өлзий | 77 | 11 | 20 | | 3 | 1 | 1 | 6 | 3 | 3 | | 1 | 2 |
| Баянгол | 45 | 10 | 14 | | 3 | | 2 | 5 | 3 | 1 | | | |
| Баян-Өндөр | 28 | 7 | 12 | | 1 | 1 | | 4 | 2 | 2 | | 1 | 1 |
| Богд | 69 | 26 | 13 | | | 1 | | 7 | 2 | 1 | | | 2 |
| Бүрд | 16 | 6 | 2 | | | | | 1 | 1 | | | | |
| Гучин-Ус | 24 | 22 | 7 | | 2 | | 2 | 1 | 1 | 1 | | | |
| Есөнзүйл | 49 | 9 | 13 | | 6 | | | 2 | 3 | 2 | | | |
| Зүүнбаян-Улаан | 129 | 34 | 16 | | 4 | | 2 | 4 | 1 | 3 | | | 2 |
| Нарийнтээл | 30 | 30 | 12 | | | | | 6 | 2 | 2 | | | 2 |
| Өлзийт | 12 | 11 | 13 | | 10 | | | 1 | 1 | 1 | | | |
| Сант | 32 | 6 | 4 | | | | | | 2 | | | | 2 |
| Тарагт | 48 | 14 | 23 | 1 | 6 | 5 | | 6 | 1 | 1 | | 1 | 2 |
| Төгрөг | 24 | 14 | 8 | | 3 | | | 2 | 1 | 2 | | | |
| Уянга | 281 | 105 | 29 | | 3 | 4 | 4 | 6 | 4 | 5 | | | 3 |
| Хайрхандулаан | 24 | 20 | 11 | | 1 | | | 6 | 1 | 3 | | | |
| Хархорин | 234 | 85 | 73 | 1 | 3 | 3 | 12 | 15 | 10 | 2 | | | 27 |
| Хужирт | 22 | 10 | 57 | | | 1 | 8 | 10 | | 5 | | | 33 |
| Арвайхээр | 926 | 605 | 581 | 3 | 158 | 21 | 102 | 84 | 64 | 51 | | 1 | 97 |
| **ДҮН** | **2085** | **1045** | **915** | **6** | **203** | **39** | **133** | **168** | **102** | **85** | | **4** | **175** |

*Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газрын мэдээг үндэслэв.*

## I.5 ГЭМТ ХЭРЭГ

I.5.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр

| Хэргийн төрөл | 2016-XI | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|---|
| Бүртгэгдсэн хэрэг-Бүгд | **474** | **477** | **637** |
| Бусдын амийг хорлосон | **6** | 4 | 4 |
| Хүчингийн хэрэг | 5 | 6 | 15 |
| Танхайн хэрэг | 13 | 3 | |
| Хулгайн хэрэг | 197 | 193 | 235 |
| Үүнээс: Хувийн өмчийн хулгай | 142 | 70 | 152 |
| Малын хулгай | 28 | 37 | 35 |
| Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 54 | 50 | 53 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 143 | 125 | 216 |
| Бусад хэрэг | 56 | 96 | 114 |
| **Гэмт хэргийн улмаас учирсан хохирол** | | | |
| Гэмтэж бэртсэн хүн | 222 | 175 | 230 |
| Нас барсан хүн | 30 | 50 | 39 |
| Нийт хохирол /сая.төг/ | 885.0 | 1007.9 | 1003.9 |
| Нөхөн төлүүлсэн хохирол | 557.0 | 345.7 | 385.5 |

I.5.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

| Сумд | 2016-XI | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|---|
| Баян-Өндөр | 15 | 12 | 8 |
| Бүрд | 11 | 16 | 14 |
| Баянгол | 3 | 8 | 12 |
| Бат-Өлзий | 22 | 31 | 52 |
| ББ-Улаан | 3 | 13 | 9 |
| Гучин-Ус | 6 | 7 | 17 |
| Есөнзүйл | 6 | 11 | 14 |
| Өлзийт | 10 | 4 | 3 |
| ЗБ-Улаан | 16 | 12 | 16 |
| Богд | 16 | 22 | 26 |
| Нарийнтээл | 7 | 11 | 21 |
| Сант | 3 | 8 | 5 |
| Тарагт | 28 | 28 | 22 |
| Төгрөг | 6 | 3 | 4 |
| Уянга | 22 | 24 | 28 |
| Хайрхандулаан | 16 | 13 | 20 |
| Хужирт | 30 | 36 | 25 |
| Хархорин | 64 | 59 | 69 |
| Арвайхээр | 190 | 159 | 272 |

| ДҮН | 474 | 477 | 637 |
|---|---|---|---|

I.5.3 ХЭРЭГТ ХОЛБОГДСОН СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

| Хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо | 2016-XI | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|---|
| **Бүгд** | **467** | **380** | **455** |
| Хэрэг үйлдэхдээ: | | | |
| -Бүлэглэсэн | 112 | 101 | 105 |
| -Согтуугаар | 138 | 97 | 171 |
| Албадан эрүүлжүүлэгдсэн хүн | 1143 | 1124 | 1393 |
| Баривчлагдсан хүн | 188 | 537 | 890 |
| Авто машин жолоодох эрх хасагдсан жолооч | 294 | 609 | 790 |

I.5.4 ХЭРЭГТ ХОЛБОГДСОН СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

| Сумд | 2016-XI | 2017-XI | 2018-XI |
|---|---|---|---|
| Баян-Өндөр | 12 | 13 | 7 |
| Бүрд | 12 | 6 | 14 |
| Баянгол | 2 | 8 | 10 |
| Бат-Өлзий | 22 | 34 | 26 |
| ББ-Улаан | 6 | 14 | 7 |
| Гучин-Ус | 6 | 3 | 10 |
| Есөнзүйл | 4 | 9 | 10 |
| Өлзийт | 8 | 2 | 1 |
| ЗБ-Улаан | 14 | 12 | 12 |
| Богд | 20 | 16 | 23 |
| Нарийнтээл | 6 | 15 | 22 |
| Сант | 4 | 6 | 6 |
| Тарагт | 24 | 16 | 14 |
| Төгрөг | 7 | 2 | 2 |
| Уянга | 26 | 19 | 24 |
| Хайрхандулаан | 17 | 16 | 15 |
| Хужирт | 26 | 28 | 9 |
| Хархорин | 54 | 49 | 33 |
| Арвайхээр | 197 | 112 | 210 |
| **ДҮН** | **467** | **380** | **455** |

*Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газрын мэдээг үндэслэв.*

## II.1 БАНК

II.1.1 ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ, ЗЭЭЛЖИГЧИЙН ТОО банкуудаар,

| Банкны нэр | Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг | | Хугацаа хэтэрсэн, сая.төг | | Зээлжигчийн тоо | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2017-XI | 2018-XI | 2017-XI | 2018-XI | 2017-XI | 2018-XI |
| **Дүн** | **171473.4** | **211595.5** | **3186.7** | **2289.2** | **35999** | **36209** |
| ХААН | 93161.7 | 103353.8 | 2615.7 | 1480.7 | 18893 | 19327 |
| ХАС | 21290.4 | 33949.6 | 475.3 | 500.4 | 3792 | 3584 |
| ГОЛОМТ | 9500.3 | 15211.1 | 79 | 261.0 | 885 | 1064 |
| ТӨРИЙН БАНК | 46900.2 | 58640.7 | 16.4 | 47.1 | 12327 | 12162 |
| КАПИТАЛ | 620.8 | 440.3 | 0.3 | | 102 | 72 |

II.1.2 ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, Х/ЭЗЭМШИГЧИЙН ТОО, банкуудаар

| Банкны нэр | Хугацаатай хадгаламж, сая.төг | | Хугацаагүй хадгаламж, сая.төг | | Хадгаламж эзэмшигчийн тоо | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2017-XI | 2018-XI | 2017-XI | 2018-XI | 2017-XI | 2018-XI |
| **Дүн** | **83255.6** | **93740.3** | **23363.4** | **30470.4** | **76708** | **79997** |
| ХААН | 41506.3 | 49290.9 | 17282.4 | 22210.9 | 33645 | 34610 |
| ХАС | 12265 | 14035.0 | 1213.2 | 1874.2 | 15784 | 15990 |
| ГОЛОМТ | 6050.3 | 5556.9 | 919.8 | 965.4 | 2155 | 2631 |
| ТӨРИЙН БАНК | 23034.3 | 24405.6 | 3896.4 | 5352.4 | 24410 | 26005 |
| КАПИТАЛ | 399.7 | 451.9 | 51.6 | 67.5 | 714 | 761 |

Эх үүсвэр: Арилжааны банкуудын мэдээг үндэслэв.

## II.2 ТӨСӨВ

II.2.1 ОРОН НУТГИЙН ОРЛОГО, ТӨСӨВ ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ,мян.төг

| Төсвийн орлого | 2018-XI | | |
|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| **Төсвийн орлого болон шилжүүлгийн дүн** | **71916184.8** | **72674643.9** | **101.1** |
| **Орон нутгийн төсвийн орлого** | **13385689.0** | **14196455.4** | **106.1** |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 8901412.6 | 9387041.0 | **105.5** |
| Орлогын албан татвар | 6504707.5 | 6583941.7 | **101.2** |
| Хувь хүний орлогын албан татвар | 7444707.5 | 7415200.9 | **99.6** |
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 6077044.6 | 5438692.3 | **89.5** |
| Үйл ажиллагааны орлого | 508837.3 | 682578.0 | **134.1** |
| Хөрөнгө борлуулсны орлого | 68513.0 | 130102.5 | **189.9** |
| Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -940000.0 | -831259.2 | **-** |
| Хөрөнгийн албан татвар | 846060.0 | 902700.9 | **106.7** |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 290000.0 | 343602.7 | **118.5** |
| Бууны албан татвар | 46060.0 | 36303.3 | **78.8** |
| Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 510000.0 | 522794.9 | **-** |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 1550645.1 | 1900398.4 | **122.6** |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 762274.1 | 736927.9 | **96.7** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 267481.4 | 242130.9 | **90.5** |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 29163.6 | 53994.8 | **185.1** |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 465629.1 | 440802.1 | **94.7** |
| Бусад татвар | 0.0 | 0.0 | **-** |
| Газрын төлбөр | 125000.0 | 110645.4 | **88.5** |
| Газрын төлбөр | 125000.0 | 110645.4 | **88.5** |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 656412.8 | 1052825.0 | **160.4** |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 123510.0 | 189970.2 | **153.8** |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 216212.8 | 490159.7 | **226.7** |
